

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ
СУМЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО**

2023 оны 04 сарын 07-ны өдөр

№03

Амардалай

ИТГЭЛТ ТӨМӨР ХЭЛХЭЭ ХХК –д





Гэрээ байгуулах эрх олгох тухай

Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 01сарын 31-ний А/15 тоот тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо нь Дэлгэрцогт сумын **"Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж тохижилт"**-ийн ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зарлаж, "Буянравжих од ХХК" "Итгэлт төмөр хэлхээ ХХК" гэсэн нийт 2 байгууллага материал ирүүлсэн байна.

Тус сумын **"Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж тохижилт"**-ийн ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд 118,222,281 / Нэг зуун арван найман сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун наян нэгэн мянган/ төгрөгөөр гүйцэтгэх тухай ирүүлсэн танай тендерийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 27.3, 28.7.3-т заасны дагуу хянан үзээд "хамгийн сайн" үнэлэгдсэнээр шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох тухай үнэлгээний хорооны дүгнэлт гаргасан.

Иймд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 29.1, 29.2-т заасны дагуу хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулна уу.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ:

ДАРГА		Н.СҮРЬЕЭРАГЧАА
НАРИЙН БИЧИГ		Б.БАТТОГТОХ
ГИШҮҮД		Г.ДЭЖИДСҮРЭН
		Д.БАЯРЖАРГАЛ
		Б.ДОВУУЧИЙ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ
СУМЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО**

2023 оны 04 сарын 07 -ны өдөр

№03

Амардалай






БУЯН АРАВЖИХ ОД ХХК –д

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 01сарын 31-ний А/15 тоот тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо нь Дэлгэрцогт сумын **"Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж тохижилт"**ийн ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу "Буянравжих од ХХК" "Итгэлт төмөр хэлхээ ХХК" гэсэн нийт 2 байгууллага материал ирүүлсэн байна.

Тус сумын **"Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж тохижилт"**-ийн ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 28.7.3-т заасны дагуу үнэлэгдсэн тендерээс илүү үнэ санал болгосон тул тендерийг хүлээн авахаас татгалзсан үнэлгээний хорооны дүгнэлт гаргалаа.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ:

ДАРГА		Н.СҮРЬЕЭРАГЧАА
НАРИЙН БИЧИГ		Б.БАТТОГТОХ
ГИШҮҮД		Г.ДЭЖИДСҮРЭН
		Д.БАЯРЖАРГАЛ
		Б.ДОВУУЧИЙ